

ШУДАРГА, ТЭНЦВЭРТЭЙ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ  
СЭТГҮҮЛЧДИЙН ҮҮРГИЙН ТУХАЙД

Р.Оюунцэцэг\*

\* МХХ, "Сэтгүүлч" коллежийн багш, докторант

**Түлхүүр үг:** сонгуулийн сурталчилгаа, сурвалжлага, мэргэжлийн түвшин, сонгуулийг сурвалжлах арга барил, сэтгүүлчдийн үүрэг.

**Сонгуулийн явцын үе шат бүрийг сурвалжлах нь хэвлэл мэдээллийнхний үүрэг**

**Ч**өлөөт ба шударга сонгуулийн кампанийн өмнөх үе, сонгуулийн кампанийн үе, тунгаан бодох үе (сурталчилгаа зогссон буюу хаасан), сонгууль өгөх өдөр, саналыг тоолж, дүнг мэдээлэх, засгийн эрхийг шилжүүлэх зэрэг бүхий л зургаан үе шатанд хэвлэл мэдээлэл ижил тэнцүү ач холбогдол өгснөөр эерэг үр дүн гардгийг гадаадын судлаач мэргэжилтнүүд ажиглажээ. Энэ нь зөвхөн сурталчилгааны үе шатуудад оногдож буй цаг хугацааны болон үйл явдлуудын өрнөлийн тухай асуудал биш юм. Тухайн хэвлэл мэдээллийнхэн сонгуулийн үйл явцтай холбоотой ямар асуудлыг онцолж, юунд ач холбогдол өгч байна гэдгээр хэмжиг-

дэнэ. Монголын туршлагаас харахад кампанит ажлыг идэвхжүүлэх хоёр дахь үе болох сонгуулийн кампанийн үеийг сэтгүүлчид илүү "тоож" сурвалжилдаг. Сонгуулийн кампанийн өмнөх үеийн мэдээллүүд сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл төдийхнээр хязгаарлагддаг гэж хэлж болно. Сонгуулийн кампанийн явцад тохиолдох онцлог асуудлын тухай тайлбар болон дүн шинжилгээ хийсэн нийтлэл, нэвтрүүлэг бараг гардаггүй. Хэвлэлийн хүрээлэнгийн 2004 оны эхэнд явуулсан нэгэн сонирхолтой судалгаа байдаг. 2000 оны 3-р улирлаас 2003 оны 4-р улирлыг дуусталх хугацааг хамарсан уг судалгаагаар УИХ-д суудалтай нам болон УИХ-ын гишүүдийн мөрийн хөтөлбөр, амлалтад сонин хэвлэлийнхэн хяналт тавьж чаддаггүй нь харагдсан юм<sup>1</sup>. Нийтлэгдсэн мэдээ, сурвалжлагын

дийлэнх нь гишүүдийн тойрогтоо ажилласан тухай, цөөн тооны ярилцлага нь тухайн гишүүнтэй мөрийн хөтөлбөрийнх нь биелэлтийг хөндсөн байв. Ийнхүү явцуурах нь өдөр тутмын, нэр хүндтэй сонинуудын хувьд нийтлэг үзэгдэл болсныг дараахь дүн ч баталж байгаа юм. УИХ-д олонх болсон МАХН-ын болон бусад суудалтай намуудын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг шүүмжлэхийн тулд биш, тэдгээрт улсуурьтай хандаж судалсан, харьцуулсан, дүн шинжилгээ өгсөн, сонгогч олны өмнө хүлээсэн хариуцлагыг нь гишүүдэд сануулсан өгүүлэл нэг ч

байгаагүй. Тиймээс сонгуулийн явц, түүний дараах үеийн нийтлэлийн бодлогыг тодорхойлж, сурвалжлахдаа редакци, сэтгүүлчид сонгогчийн өмнөөс асуудалд хандах нь чухал бөгөөд үр дүнтэй байх болно. Тухайлбал, нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах хөрөнгийн хэмжээ хуулиар тогтоосон хэмжээнээс хальж байна уу, тэрээр сонгогчийг худалдан авах оролдлого хийж шударга бус загнаж байна уу, төрийн байгууллагын өмч хөрөнгийг өөрийн сурталчилгаандаа ашиглаж байна уу гэх мэт. Түүнчлэн олон нийтийн оролцоог хан-

гасан ба өрсөлдөгч талуудын төлөөлөл бүхий нийтлэл, нэвтрүүлэг, халз маргаан зохион байгуулах нь чухал юм. Энэ нь улс төрийн үйл явдлыг идэвхтэй сурвалжилж, бодитой харуулах, уншигч, сонсогч, үзэгчийн санаа бодлыг төвлөрүүлэх, тэдний өмнөөс төр засгийг хянах

зэрэг хэвлэл мэдээллийн үндсэн үүргээ хангахад тус болно. Тиймээс чөлөөт, шударга сонгуулийн үе шат бүхэнд, эхнээс нь авахуулаад шийдвэрлэх үе хүртэл сэтгүүлчид ухамсартай, хариуцлагатай ажиллах шаардлагатай юм. Сонгуулийн үйл явц дуусгавар болсон ч тэд төр засгийн

«

*Сонгуулийн үйл явц дуусгавар болсон ч тэд төр засгийн албан тушаалтнуудад сонгуулийн амлалтыг нь дахин сануулж, хэрэв биелэх нөхцөлгүй бол чухам ямар шалтгаанаар гэдэг тайлбар авч, олон түмнийг зовоож байгаа бусад чухал асуудлын талаар ямар санаа бодолтой байгааг нь сурвалжилж үйл ажиллагаа бүртээ үүрэг хариуцлага хүлээснийг нь мэдрүүлэх явдал бол хэвлэл мэдээллийнхний гол үүрэг мөн.*

»

албан тушаалтнуудад сонгуулийн амлалтыг нь дахин сануулж, хэрэв биелэх нөхцөлгүй бол чухам ямар шалтгаанаар гэдэг тайлбар авч, олон түмнийг зовоож байгаа бусад чухал асуудлын талаар ямар санаа бодолтой байгааг нь сурвалжилж үйл ажиллагаа бүртээ үүрэг хариуцлага хүлээснийг нь мэдрүүлэх хэвлэл мэдээллийнхэн гол үүрэг гүйцэтгэдэг гэж мэргэжилтнүүд үздэг.

**Сурвалжлах явцад мөрдөх зарчмууд**

Хэвлэл, мэдээлэл нь сонгогч болон сонгогдож гарч ирэх буюу ирсэн төлөө-



лөгчийн хооронд л мэдээллийг дамжуулах хялбархан үүрэг гүйцэтгэхгүй гэдгийг дээр тэмдэглэсэн. Харин төрийн түшээ байх шаардлага шалгуурыг тухайн нэр дэвшигч хэр хангаж байна, хэнд сонгогчид өөрсдийн өмнөөс итгэл хүлээлгэж болохуйц байна, төрийн түшээ хүний хариуцлагыг дааж авч явах чадвар хэнд нь илүү ажиглагдаж байгаа зэргийг сонгогчдод харуулахуйц маргаан хэлцлийг өрнүүлэх талбар нь болох ёстой юм.

**И**йнхүү "хэлэлцүүлэг, маргааны чөлөөт индрийн үүрэг" гүйцэтгэхдээ сэтгүүлчид үзэл бодол ба тайлбар өгөх асуудлыг Европын Хүний эрхийн Шүүхээс баталгаажуулснаар "хэвлэлийн үүрэг нь мэдээлэл түгээх бөгөөд тайлбар хийх эрхийг уншигчид үлдээх ёстой"<sup>2</sup> билээ. Тиймээс сонгуулийг сурвалжлах явцад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын мөрдөх үндсэн зарчим бол цэвэр мэдээлэл, баримт ба үзэл бодол, тайлбарыг ойлгомжтойгоор ялгаж салган өгөх юм. Олон нийтийн санаа бодлыг тодорхой асуудалд төвлөрүүлэх үүднээс олж цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж, зохих тайлбарыг сэтгүүлчийн зүгээс өгөх шаардлага гарсан тохиолдолд тэр нь өөрийн өгч буй тайлбар дүгнэлт гэдгийг тодорхой илэрхийлэх нь зүйн хэрэг. Ингэж чадаж гэмээ нь өгч буй бүх мэдээлэл хэнийг юуны төлөө сонгож байгаагаа мэдэхэд сонгогчдод туслаад зогсохгүй, "тухайн хэвлэл мэдээллийн

байгууллага, тодорхой сэтгүүлч жинхэнэ мэдээ ба сонгуулийн ухуулга сурталчилгаа хоёрын алиныг нь хүргэж байгааг таньж мэдэх боломжийг сонгогчид олгоно"<sup>3</sup>.

Сонгуулийн үед хэвлэл мэдээлэл сонгогчдыг гэгээрүүлж, нам болоод нэр дэвшигчдэд ялгаваргүй хандахын тулд кампанит ажлын сурталчилгааг тэнцвэртэй, шударга явуулах зарчмыг баримтална. Энэ нь нэр дэвшигчийн танилцуулга, үг, түүний мөрийн хөтөлбөрийн тайлбар, тэнгэрт тулсан магтаал хөрөг зэрэг улиг болсон үйл явдлын шууд дамжуулах хэлбэрүүдээс сэтгүүлчид татгалзаж, тухайн нэр дэвшигчийн өөрийнх нь нээлттэй байдал, сонгогчидтой ойлголцох, өөрийгээ таниулах чадвар зэрэг үйл явдлын сонирхолтой талуудыг олж мэдээлэх нь бодит байдалд илүү нийцнэ. Энэ нь сонгогчидтой хийх уулзалт, нэр дэвшигчдийн оролцсон маргаан мэтгэлцээн, шууд асуулт хариулт зэрэг олон хэлбэрийн арга хэмжээнүүдээс илт тодорхой харагдах тул энэ тохиолдолд тухайн мэдээллийг хэрхэн яаж боловсруулах нь сэтгүүлчийн бүтээлч бөгөөд мэргэжлийн хандлагаас хамаарна. Нэг үгээр, нам, нэр дэвшигчийг дагаж бус сэтгүүлч өөрөө мэргэжлийн үүднээс хандаж ажиллавал тэднийг (нам, нэр дэвшигч) үнэлэх сонгогчийн үнэлэмж өснө. Улмаар амьд үйл явдлын сурвалжлагууд нь сонгогчийн сонголт хийх шийдвэрт эерэгээр нөлөөлөх боломж

өндөртэй гэж үздэг юм. "Дэлхийн нэлээд олон орны жишээнээс үзэхэд нэр дэвшигчид зарим мэдлэг сорьдог шоу (Тайван), мөн урлаг соёл, тэр ч байтугай хоол хийх, машин уралдааны (Эстони) тухай нэвтрүүлгийн зочин буюу хөтлөгчөөр оролцдог байна.

Тэнцвэрт байдлынхаа төлөө санаа тавьж байдаг хэвлэл, мэдээллийн байгууллагынхан гагцхүү өөрсдөө янз бүрийн нам буюу нэр дэвшигчдэд хэрхэн хандахыгаа цэгнэж үзэх хэрэгтэй. Нөгөө талаас улс төрийн албан тушаалын ур чадвараар нь сонголт хийх ёстой сонгогчид зарим нэр дэвшигчдийн өвөрмөц байдлыг хүндэтгэж үзэж ч болох талтай"<sup>4</sup>.

Хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид байр сууриа зөв тодорхойлж илэрхийлснээр сонгогчдод өөрсдийнхөө хүсэл зоригийн эсрэг авилга, дарамт шахалтад авталгүйгээр төр, засгийн газраа сонгох боломжтой гэсэн санамж, мэдээллийг хүргэх болно. Сонгогчийн боловсрол нь сонгуульд хэрхэн оролцохоор хязгаарлах бус илүү өргөн хүрээний асуудал бөгөөд тэднийг намуудаас мэдээлэл эрж хайдаг, нэр дэвшигчдээс асуулт асуудаг, сонгуулийн кампанийн үйл явцад идэвхтэй оролцдог болгох ёстой. Энэ соёлыг хэвлэл мэдээлэл л нэвтрүүлнэ.

**Өөрийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэх нь**

Ардчилалд шилжих явцад шударга, тэнцвэртэй байдлаа сайжруулах зорилгоор хэвлэл, мэдээлэл хуучин зуршлаасаа салахыг эрмэлздэг. Нөгөө талаар, "Сонгуулийн үйл явц нь сэтгүүл зүйн мэргэжлийн чанар чансааг шалгах том тест, шалгуур"<sup>5</sup> гэж тооцдог. Харин хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн үеэр шударга, тэнцвэртэй сурталчилгаа явуулж чадсан эсэхээ өөрийн буюу бусад байгууллагуудын тусламжтай хянаж болно. Ингэснээр өөрийн үйл ажиллагааг шүүмжлэлтэйгээр дүгнэж цэгнэх боломжтой.

**С**онгуулийн үйл явцын саналыг тоолж, дүнг мэдээлэх тавдугаар үеийг сонгож, янз бүрийн хэвлэл мэдээлэл тодорхой хугацаанд түүнийг хэрхэн тусган харуулсныг судалъя гэж бодъё. Үүнийг мэдээллийн хөтөлбөрийн хүрээнд болон сонины мэдээний нүүртэй харьцуулан бүтэц, агуулгын талаас шинжилсний үр дүнд хэл, найруулгын шийдэл хийсэн байдал, тухайн асуудалд хандсан байдал зэргийг тодорхой үзүүлэлтүүдээр гаргаж ирж болох юм. Хэвлэл мэдээллийн эдгээр шийдэл нь уншигч, үзэгч, сонсогчдод хэрхэн нөлөөлөх талаар эцэст нь тодорхой таамаглал, дүгнэлтүүдийг дэвшүүлж, эргэлзээт байдлаас гарах боломжийг харуулна. Энэ нь уншигч, сонсогч, үзэгчдээ хүндэтгэсэн том алхам, нөгөөтэйгүүр тэдний итгэл үнэмшлийг олж авах гарц юм.



ХАВСРАЛТ 1 (Өөрийн үйл ажиллагааг хянах агуулгын судалгааны нэг үзүүлэлтийн жишээ)

Аливаа сэдэв, асуудлаар тодорхой тайлбар хийхдээ гуйвуулсан үг хэллэг ашигласан байж болох хэд хэдэн аргыг "Хэвлэл мэдээлэл ба сонгууль" гарын авлагад дурджээ.

Үүнд:

■ Ямар өнцгөөс үйл явдлыг дүрсэлсэн байна вэ? Тэр санаа нь сэтгүүлчийн өөрийнх нь, эсвэл нэр дэвшигчийн, эсвэл олон нийтийн төлөөлөгчийнх байж болно. Тэр санааг илэрхийлсэн үг хэллэг нь аль нэг намын талд таатай сэтгэгдэл төрүүлж магад.

■ Үнэлэлт өгсөн нэр томъёо хэрэглэсэн эсэх. Өгүүлбэрийн нарийн мэдрэмжид нөлөөлөх нюанс бүхий үгс бий. Үүний сонгодог жишээнд босогчдын бүлгийг "эрх чөлөөний төлөө тэмцэгч", эсвэл "алан хядагч" хоёрын алинаар нь нэрлэх вэ гэдэг орно. Нэг үйл явдлыг хоёр өөр төлөв байдлаас хэлсэн жишээ бас бий. Тухайлбал, "Засгийн газар мэдэгдэв...", "Сөрөг хүчин мэдэгдэл хийв..." гэж хэлэхэд аль талд нь илүү итгэл өгч байгаа нь харагдаж байна.

■ Эерэг болон сөрөг нэр томъёог тухайн орон нутаг, цаг үетэй нь хамааруулж авч үзэж болно. Жишээ нь, "дэвшилтэт", "өөрөөр сэтгэгчид" гэдэг үгс эерэг үү, сөрөг үү? Ийм нэр томъёо түрүүчийн дэглэмийн үед, хүн амын цөөнхөд буюу хөрш орнуудад хандах хандлагатай холбоотой байж болох. Анхны ажиглалт дээрээ тулгуурлан зарим нэр томъёоны тайлбар бүхий жагсаалтыг гаргахад ч илүүдэхгүй.

■ Бүрхэг байдал, нарийвчилсан мэдээлэл дутагдаж байгаа нь хариуцлагаас нуугдаж байгаа хэлбэр. Жишээ нь, "Цагдаагийнхантай буудалцахад гурван хүн нас

барлаа" гэвэл эндээс хариулт авахаасаа илүү олон асуулт төрж гарна. Хэн хэнийгээ алаа вэ? Нас барсан хүмүүс нь энгийн хүмүүс юм уу, цагдаа нар уу? Хэн эхэлж гал нээв? Яагаад тэд тулалдав? Хаана, хэзээ болов? Энгийн хүмүүс буутай байсан уу? гэх мэт.

■ Дээрхийн эсрэг хэтэрхий их нарийвчилсан зүйл өгсөн мөртөө ашигтай мэдээлэл өгөөгүй тохиолдол бас бий. Жишээ нь, "Өнөөдөр жагсаал болж, жагсагчид хог их хаялаа. Ялангуяа парламентын өмнөх цэцэрлэгт гудамжинд

«

*Хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид байр сууриа зөв тодорхойлсноор сонгогчдод өөрсдийнхөө хүсэл зоригийн эсрэг авилга, даралт шахалтад авталгүйгээр төр, засгийн газраа сонгох боломжтойг ойлгуулна. Сонгогчийн боловсрол нь сонгуульд хэрхэн оролцохоор хязгаарлах бус, тэднийг намуудаас мэдээлэл эрж хайдаг, нэр дэвшигчдээс асуулт асуудаг, сонгуулийн кампанийн үйл явцад идэвхтэй оролцдог болгох ёстой.*

»

их хог хаяжээ" гэвэл их л нарийн зүйл хэлээд байгаа юм шиг мөртлөө хэн, юу, яагаад, яаж гэсэн асуултад бүрэн хариулахгүй л байна.

Энэ мэтчилэн нарийн ажиглалт, судалгаа хийж өөрийн үйл ажиллагааг хянаж, дүн шинжилгээ хийснээр ирээдүйд гарах алдааг урьдчилан сэргийлэх, тэгснээр мэргэжлийн түвшинд ажиллах шаардлагыг илүү ухамсарлах болно.

## ХАВСРАЛТ 2

Хүний эрхийн Европын шүүхийн бий болгосон зарчмууд

**Э**нэхүү зарчмууд нь сонгуулийн үеийн улс төрийн маргаан хэлэлцүүлэгтэй туйлын холбоотой бөгөөд эдгээрийг прокурор болон шүүхүүд хатуу хүндэтгэх ёстой.

▪ Олон нийтийн өмнөөс хоточ нохойн үүргийг гүйцэтгэх явцдаа хэвлэл мэдээлэл нь иргэдийн санаа бодлыг төлөвшүүлэхдээ олон түмний эрх ашгийн үүднээс хандах онцгой үүрэг хүлээнэ. Энэ нь улс төрийн шинжтэй буюу олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн сэдвийг тайлбарлахдаа хэвлэл мэдээлэл нь тусгайлсан эрх чөлөөг шаардаж байна гэсэн үг. Ялангуяа сонгуулийн үед хэвлэл мэдээлэл улс төрийн амьдралын олон талыг ойроос харж, нарийвчлан дүгнэж байгааг тэвчээртэйгээр ажиглах шаардлагатай болох нь ойлгомжтой.

▪ Сонгогдсон төлөөлөгчид ялангуяа сөрөг хүчнээс сонгогдсон гишүүд олон

нийттэй холбоотой асуудал буюу засгийн газрын гишүүдийн үйл ажиллагааны талаар тайлбар хийх онцгой эрхтэй байдаг. Энэ нь улс төрийн албан тушаалд нэр дэвшигчдэд ч хамаатай зүйл.

▪ Хувь хүмүүсийг шүүмжлэхээс илүү засгийн газрын гишүүд болон улс төрчдийг шүүмжлэх хүрээ нь өргөн байдаг. Нэр дурдаагүй шүүмжлэл ч өргөн байна. Сонгуулийн үед засгийн газрын үйл ажиллагааг шинэчлэх санал шүүмжлэл их гарч ирнэ. Тэгээд сонгуулийн кампанит ажлын турш төр засгийн байгууллагын бүтэц зохион байгуулалтын талаар чухал маргаан хэлэлцүүлэг явагдана.

▪ Ялагдсан хүн олон нийтийн санаа бодлыг тусгаж өөрөө болон бусдын хэлсэн зүйлийн үнэн зөвийг батлах албагүй. Хэвлэл мэдээлэл сонгуулийн үед баримт сэлт дээр тулгуурласнаас илүү үзэл бодол, хов жив дээр түшиглэсэн олон нийтийн болон тоймчдын санаа бодлыг тавьдаг. Хэрвээ хэвлэл мэдээлэл сонгуулийн үеийн хэлэлцүүлэг маргааныг өргөнөөр тусган харуулах гэж байгаа бол юунаас ч айж эмээлгүй тавих хэрэгтэй.

▪ Нэр төр сэргээх гомдлоо өдсөн, уурлаж уцаарласан шинжтэй илэрхийлэх нь аливаа нэр төр сэргээх асуудлыг сулавтар шинжтэй болгодог. Кампанит ажил ид буцалж байгаа үед нэр дэвшигч болон бусад хүмүүс ижилхэн хариулт шаарддаг өдөөн хатгасан асуултаас

эвтэйхэн тойрон гарч чаддаг байх хэрэгтэй. Сонгогчид нэр дэвшигчдийн жинхэнэ үзэл санааг мэдэж аваад үнэхээр хүчтэй эсэхийг нь шалгахыг зорьж байгаа учир тийм омогтой маргааныг сонгуулийн үед тэвчээд гарах хэрэгтэй.

### Ишлэл

<sup>1</sup> 2004. "УИХ-д суудалтай нам болон УИХ-ын гишүүдийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сурвалжилсан байдал" эмхэтгэл, МХХ.

<sup>2</sup> Helen Darbshire. Media and democracy, Chapter 4 – Media and electoral process.

<sup>3</sup> Мөн тэнд.

<sup>4</sup> Мөн тэнд.

<sup>5</sup> IFJ, Election reporting handbook.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2004. "УИХ-д суудалтай нам болон УИХ-ын гишүүдийн мөрийн хөтөлбөрийн

хэрэгжилтийг сурвалжилсан байдал" эмхэтгэл, МХХ.

2. Helen Darbshire. Media and democracy, Chapter 4 – Media and electoral process.

3. IFJ, Election reporting handbook.

4. Томас Виншир. Сэтгүүлчид, хэвлэн нийтлэгчдэд зориулсан өгүүлэл.

5. Деннис Пиерс. Олон нийтийн сонгууль ба хэвлэл мэдээлэл, лекц.

### Resume

Because of possibilities of using an international journalists's experiences and printed handouts on election and media, which considered all issues and challenges facing transitional period countries, Mongolian journalists could make a good election reporting. It's just enough to understand and follow the rules and guidelines for election reporting.